

СОР ХК-ИЙН 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Тус компани нь Монгол улсын хууль, Компанийн тухай хууль, НББ болон Татварын хууль, бусад хууль дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус компанийн ТУЗ нь 2018 онд хоёр удаа хуралдаж хоёр асуудал хэлэлцэн тогтоол гаргасан болно.

Компанийн ТУЗ нь Сор ХК-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах, одоогийн нөхцөл боломжит зах зээлийг олох, Олон улсын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмж, техник технологийг нэвтрүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэтийн зорилтыг тавин Гүйцэтгэх захиралд үүрэг болгон ажиллаж байна. Компанийн хувьд одоогийн байдлаар түрээсийн үйл ажиллагаа явуулж байгаа ба цаашдаа жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Засгийн газрын бодлогын хүрээнд үйл ажиллагаа явуулахаар судалгаа хийж байна. Өнөөдрийн байдлаар “Ус суваг удирдах газар”-ын Урьдчилан цэвэрлэх байгууламж нь арьс ширний хашаанд байрлах үйлдвэрүүдийн бохирын ачаалаа дийлэхгүй байгаа нь манай байгууллагын хувьд багагүй асуудал болж байна. Арьс ширний хашаан дотор байрлах үйлдвэрүүд нь нийтийн эзэмшийн талбай болон авто машины зам, явган хүний зорчих хэсэг гэх мэт газруудаар үйлдвэрийн технологийн бохир усаа шууд задгай асгаж байгаа нь ихээхэн сөргөөр нөлөөлж байна. Одоогийн байдлаар компанийн хүрээлэн буй орчны нөлөө хэт их бохирдолтой, эрсдэл өндөр байгаа тул компанийн үйл ажиллагаанд доривтой дэвшилт гаргах боломжгүй байна.

2. Удирдлагын талаарх мэдээлэл

Тус компани нь Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Сантехник агааржуулалтын инженер, Харуурууд гэсэн бүтэц орон тоотой ажиллаж байна.

Гүйцэтгэх захирал Е.Булган сайхан нь 1990 онд төрсөн. 1998-2008 онд 10-н жилийн дунд сургууль, 2008-2012 онд Олон улсын эрх зүйч мэргэжлээр бакалавр, 2012-2014 онд Хууль зүйн магистер зэргээг тус тус төгссөн. 2012-2013 онд Улсын бүртгэл ерөнхий газар гэрээт, 2013-2016 онд Шүүхийн ерөнхий зөвлөлд Ахлах техникч, 2016 оны 01 дүгээр сараас Сор ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Ерөнхий нягтлан бодогч Ц.Цэцгээ нь 1960 онд төрсөн. 1978 онд 10 жилийн дунд сургууль, 1982 онд Аж үйлдвэрийн нягтлан бодогч мэргэжлээр, 2002 онд онд нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр, 1998 онд Сингапур Улсад нягтлан бодох бүртгэл аудитын чиглэлээр тус тус суралцсан. 1978-1982 онд Ажилчны районы нэгдсэн эмнэлэгт нягтлан бодогч, 1982-2010 онд “Говь” ХК-д нягтлан бодогч, 2011 оноос Блю скай кашемир ХХК-д нягтлан бодогчоор ажиллаж байна.

3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл

2018 онд 4878 м^2 талбай түрээслүүлж 212,4 сая төгрөгийн орлоготой ажилласан. Харин үйл ажиллагааны зардлын нийт дүн 160,6 сая төгрөг болсон ба 46,6 сая төгрөнийг цэвэр ашигтай ажилласан. Нийт зардлын дүнгийн 13% нь ерөнхий удирдлагын зардал, 46,8%-ийг цалингийн зардал, 1,4%-ийг засвар үйлчилгээний зардал, 16,6%-ийг элэгдлийн зардал, 22,2%-ийг бусад зардал эзэлж байна.

“СОР” ХК-ИЙН 2018 ОНЫ ТАЙЛАН ТЭНЦЭЛ

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2016.12.31	2017.12.31	2018.12.31	Өөрчлөлт	
				<u>2017</u>	<u>2018</u>
				2016	2017
Эргэлтийн хөрөнгө	11,629,716,947	7,506,592,232	7,244,654,869	55%	4%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,378,300.57	765,054.54	1,215,415.04	80%	-37%
Авлага	11,628,338,646	7,505,659,605	7,243,439,454	55%	4%
Бараа материал		167,572.06		-100%	
Эргэлтийн бус хөрөнгө	931,118,905	904,273,479	1,004,078,778	3%	-10%
Биет хөрөнгө	930,802,141	904,002,210	1,003,853,004	3%	-10%
Биет бус хөрөнгө	316,764	271,269	225,774	17%	20%
НИЙТ ХӨРӨНГӨ	12,560,835,852	8,410,865,711	8,248,733,647	49%	2%
Богино хугацаат өр төлбөр (БХӨТ)	7,923,913,865	7,686,690,377	7,477,882,056	3%	3%
Бэлтгэн нийлүүлэгчид төлөх өглөг	79,096,418	30,124,950	25,374,303	163%	19%
Банкны богино хугацаат зээл					
Бусад БХӨТ***	7,844,817,447	7,656,565,427	7,452,507,753	2%	3%
Урт хугацаат өр төлбөр (УХӨТ)	4,180,000,000	244,807,610	244,807,610	1607%	0%
Банкны зээл	4,180,000,000	244,807,610	244,807,610	1607%	0%
Эзэмшигчдийн өмч	456,921,986	479,367,724	526,043,980	-5%	-9%
Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	12,560,835,852	8,410,865,711	8,248,733,647	49%	2%

“СОР” ХК-ИЙН 2018 ОНЫ ОРЛОГЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2016 он	2017 он	2018 он	Өөрчлөлт	
				<u>2017</u>	<u>2018</u>
				2016	2017
Борлуулалт					
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг					
Бохир ашиг					
Үйл ажиллагааны зардал	75,539,638	120,202,989	115,353,930	-37%	4%
Үйл ажиллагааны бус орлого	128,540,994	188,988,352	212,483,724	-32%	-11%
Үйл ажиллагааны бус зардал	43,411,681	43,845,655	45,267,286	-1%	-3%
Татварын өмнөх ашиг	9,589,674.95	24,939,708.38	51,862,507.12		
Татвар	958,967.49	2,493,970.83	5,186,250.71		
Цэвэр ашиг	8,630,707.46	22,445,737.55	46,676,256.41		

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

ҮЦ ЭЗЭМШИГЧДИЙН НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД					
Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа 2019 оны 04-р сарын 05-ны өдрийн байдлаар хувьцааны тоо ширхэг 891,388, Хувьцаа эзэмшигчдийн тоо 1,682 байна.					
№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	тоо ширхэг	Эзлэх хувь	Брокер ДК-иудын нэр	регистрийн дугаар
1	Блю скай кашемир ХХК	420,671	47.19	Гендекс	5209811
2	Титан инвест ХХК	151,000	16.94	Гендекс	2807386
3	Монгол даатгал ХХК	75,337	8.45	Бумбат Алтай ҮЦК ХХК	2117525

5. Ногдол ашигийн талаарх мэдээлэл

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02-р сарын 18-ны өдрийн Дугаар 19/01 тоот тогтоолоор Сор ХК нь 2018 оны байдлаар нийт 46,676,256 /дөчин зургаан сая зургаан зуун далан зургаан мянга хоёр зуун тавин зургаа/ төгрөгийн ашигтай ажилласан ба ногдол ашиг хувиарлахад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс бага, төлбөрийн чадваргүй байх тул 2018 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

6. Бусад шаардлагатай мэдээлэл

Компаний ТУЗ нь 9 гишүүнтэй.

Үүнд: **ТУЗ-ийн даргаар И.Дариймаа**

Буурлууд овгийн Ишхүүгийн Дариймаа 1964 оны 5-р сарын 12-ны өдөр Ховд аймагт төрсөн, 1972-1982 онд ерөнхий боловсролын сургууль, 1982-1986 онд МУИС-ийн Эдийн засгийн Факультетийг статистикч-эдийн засгийн ухааны бакалавр, 1996 онд мэргэшсэн нягтлан бодогчдын институтыг нягтлан бодогч мэргэжлээр дээшлүүлсэн, 1998-1999 онд Техникийн их сургуулийн Бизнесс удирдлагын магистр, 2000 онд Тайланд улсад “SIAM” дээд сургуульд эдийн засгийн чиглэлээр, Английн Лондон хотод Олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө болгох сургалтанд хамрагдаж тус тус мэргэжил дээшлүүлсэн. 1986-1988 онд Ховд аймгийн АДХ-ийн гүйцэтгэх захиргаанд үйлдвэр, худалдаа хариуцсан мэргэжилтэн, 1988-2009 онд Говь ХК-нд мастер, эдийн засагч, нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, 2010 оны 3 сарын 15-наас өнөөг хүртэл Блю скай кашемир ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна. худалдааны тэргүүний ажилтан.

ТУЗ-ийн гишүүд:

Бэрсүд овгийн Доржсүрэнгийн Мөнхдэлгэр 1969 оны 07-р сарын 06-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, 1977-1987 онд ерөнхий боловсролын сургууль, 1992-1996 онд МУИС-ийн Үйлдвэрлэлийн удирдлага, эдийн засагч бакалавр, 1996-1999 онд Хотын захиргаанд мэргэжилтэн, 1999-2008 онд Бодь групп Эдийн засагч, 2008 оноос өнөөдрийг хүртэл Титан лизинг ХХК-д Гүйцэтгэх захирлаар, 2017 оноос Блю скай кашемир ХХК-нд Ерөнхий захирлаар тус тус ажиллаж байна.

Светлана Быканова ОХУ-ын иргэн 1989 оны 09 сарын 15-ны өдөр ОХУ-д төрсөн, дизайнер маркетологич мэргэжилтэй, 2009 онд ОХУ-д Худалдааны дээд сургуулийг маркетологич мэргэжлээр дүүргэсэн, 2009 оны 10-р сарын 27-ноос өнөөг хүртэл Блю скай кашемир ХХК-нд Маркетинг худалдааны газрын захирлаар ажиллаж байна.

Паномарёва Светлана 1975 оны 10 сарын 20-нд ОХУ-ын Курск хотод төрсөн, 1997 онд Курск хотын багшийн их сургуулийг гадаад хэлний багш мэргэжлээр төгссөн, Гадаад худалдааны зөвлөх.

Бэсүд овгийн Бавуудоржийн Мөнхтуул 1973 оны 03 сарын 18-ны өдөр УБ хотод төрсөн, 1980-1990 онд зөвлөлтийн нэрэмжит 14-р сургуулийг бүрэн дунд боловсролоор, 1991-1995 онд Политехникийн багшийн дээд сургуулийг Санхүү менежментийн бакалавраар, 1997-2001 онд Москвагийн их сургуулийг Санхүү менежментийн магистраар, 2003-2004 онд Москвагийн их сургуулийг Эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн, 2000 онд Аудитрын курс, 2004 оны 02 сарын 02-ноос 2011 оны 6 сарын 11-ийг хүртэл “Чингис хаан” банкинд Аудитороор, 2011 оны 08 сарын 11-ний өдрөөс өнөөг хүртэл “Монгол Факторинг” ХХК-ний захирлаар ажиллаж байна.

Ургат овгийн Есөн-Өрлөгийн Булган сайхан 1990 оны 09 дүгээр сарын 21-нд Архангай аймаг Эрдэнэмандал суманд төрсөн. 1998-2008 онд Эрдэнэмандал сумын 10-н жилийн дунд сургууль, 2008-2012 онд Улаанбаатар хот Отгонтэнгэр Их сургууль Хууль зүйн сургуулийг Олон улсын эрх зүйч мэргэжлээр бакалавр, 2012-2014 онд Хууль зүйн магистер зэргээг тус тус төгссөн. 2012-2013 онд Улсын бүртгэл ерөнхий газар гэрээт, 2013-2016 онд Шүүхийн ерөнхий зөвлөлд Ахлах техникч, 2016 оны 01 дүгээр сараас Блю скай кашемир ХХК-ийн Хуулийн зөвлөхөөр ажиллаж байна.

Цэрэндаваа овогтой Ганчимэг 1967 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр төрсөн. 1985-1987 онд Монгол Улсын Их сургууль, 1987-1991 онд Бээжингийн их сургуульд судлаачаар тус тус төгссөн. 1992-2000 онд Үйлдвэр худалдааны яамны Гадаадын хөрөнгө оруулалтын агентлаг, 2000-2016 онд Чингис хаан банкны ТУЗ-ын Ажлын албаны дарга, 2016 оноос одоог хүртэл “Монгол даатгал” ХХК-ийн ТУЗ-ын Ажлын албаны дарга албан тушаалд ажиллаж байна.

Оточ овгийн Цогтбалын Мандурай 1986 оны 11 сарын 20-нд төрсөн. 1993-2003 онд нийслэлийн 10-н жилийн 93-р дунд сургуулть, 2003-2007 онд “Mongolia International University” дээд сургуулийг олон улсын бизнес удирдлагын бакалавр, 2008 онд Блүүмберг агентлагийн “BU training in UB” сургалт, 2008 онд МСЗХ-ны “Олон Улсын Санхүүгийн зах зээл” сэдэвт сургалт, 2008 онд МСЗХ-ны “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийн сургалт”-аар Үнэт цаасны зах зээлд ажиллах эрхийн үнэмлэх №386, 2008 онд МХБ-ийн “Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийн сургалт”-аар диллериин үнэмлэх №097, 2011.06.29-2011.09.16 “Хөрөнгийн зах зээлийн сургалт” Лондонгийн хөрөнгийн биржийг тус тус суралцсан. 2006.11-2007.02 сар “LTC Solutions” ХХК-нд Intern, Administrative assistant, HR and Finance Department: Accountant assistant, 2008.04-2010.01 сар “Asia Pacific Securities” ХХК-нд брокер, диллер, 2010.01 сараас “Гендекс” ХХК брокер, диллер, 2016 оны 07 дугаар сараас өнөөн хүртэл Титан инвест ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Хээхий Дарам Лизунова Таня 1983 оны 02 дугаар сарын 19-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн. 1990-1993 Орос-Монголын хамтарсан 10 жилийн 3 дугаар дунд сургууль, 1993-2000 ОХУ-ын ЭСЯ-ны дэргэдэх 10 жилийн дунд сургууль Бурэн дунд боловсрол, 2000-2004 МУИС, ЭЗС-ийн Банк санхүүгийн анги. Бакалавр зэрэг, 2004-2006 ХБНГУ-ын Гамбург хотод Герман хэлний курс тус тус сурч төгссөн.

2006-2016 Чингис Хаан банканд Гадаад харилцааны ажилтан, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Судалгааны хэлтсийн захирал, ТУЗ-ийн ажлын албанд, 2016 оноос өнөөдрийг хүртэл Монгол Даатгал ХХК ТУЗ-ийн даргын туслахаар ажиллаж байна.

Компани нь өнөөдрийн байдлаар өөрийн үйл ажиллагааг явуулах боломжгүй байгаатай холбогдуулан өөрийн үйлдвэрийн байрны талбайг түрээслүүлэн ажиллаж байгаа ба түрээсийн ашгаар өөрийн зардлыг нөхөн ажиллаж байна.

Компанийн ТУЗ нь цалин, урамшуулалгүй ажиллаж байна. Харин Гүйцэтгэх захирал 800,000 төгрөг, Ерөнхий нягтлан бодогч 500,000 төгрөгийн цалинтай ажиллаж байна.

Дээрх ТУЗ болон гүйцэтгэх удирдлага болох эрх бүхий албан тушаалтан нь Компанийн хувьцаа эзэмшдэггүй болно.